

1980-1990-ЭЭД ОНЫ ТОГТМОЛ ХЭВЛЭЛ ДЭХ
ЭКОЛОГИЙН НИЙТЛЭЛ

Л.Ариун*

* ХИС-ийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

Түлхүүр үг: экологийн сэтгүүл зүй, байгаль орчны үндсэн сэдвүүд, иргэдийн захидал, бичлэгийн төрөл, зүйл.

Экологийн сэтгүүл зүй нь иргэдийн байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах санаа сэдлийг төрүүлэх зорилготой олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжиж буй нийтлэл, нэвтрүүлгийн цогц юм. Байгаль орчны сэдэв глобаль шинжтэй, хүн бүрийн амьдрал ахуйд их ойрхон асуудал мөн. Хүний буруу үйл ажиллагааны уршиг болж байгалиас ирж болох аюул заналхийллийг хамгийн бодитоор дүрслэн харуулах, уншигч олон нийтэд мэдрүүлэх хэрэгсэл бол нийтийн мэдээллийн хэрэгсэл байдаг. Тиймээс олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байгаль орчны асуудлыг хэрхэн тусгаж ирж вэ, яаж тусгавал үр нөлөө сайтай болох вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд үүсч хөгжсөн тэр

цагаасаа экологи, байгаль орчны сэдэвтэй асуудал дэвшүүлсэн мэдээ материал нийтэлж ирсэн байдаг. Монгол орны байгалийн баялаг, түүний ашиглалт, хамгаалалтын талаарх анхны нийтлэл Нийслэл хүрээнд Хятадын Баруун хойт хязгаарын хэрэг шийтгэх яам гэгч 1919 оны 2-р хагаст гаргаж байсан "Шо фаны өдрийн сэтгүүл"-д хэвлэгдэж байжээ. Хятадын түргэмгийлэгчдийн эзэрхэг бодлогыг сурталчлахад чиглэсэн уг сонины нэгэн дугаарт: "Монголчууд хэдий үнэхээрийн аргал түлш голдуу хэрэглэдэг боловч сүүл сүүлдээ мод түлэх нь үлэмж болов. Иймд ой мод барагдан дуусч магадгүй тул албаны хүн томилж, ой модыг давхар мануулав. Хойшид харьяат яамны газар мэдүүлж байцаалгын тасалбар авалгүй мод цавчихыг эрс хориглосугай" гээд Хайрхан уул, Туул, Сэлбэ голын хавиас мод бэлтгэх, эдгээр газраас ан агнах, загас барихыг чандалсан тухай мэдээлж байжээ.

"Хэдийгээр Монгол орны байгаль, түүний баялгийг хамгаалах шийдвэр гаргаж, энэ тухайгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан нь дэвшилтэт мэт боловч үнэн хэрэг дээрээ монголчуудыг эх нутагт нь ямар ч эрх мэдэлгүй боол мэт байлгах харгис, дээрэнгүй шинж чанартай тушаал байсан юм" хэмээн судлаачид тэмдэглэжээ. Энэ бол манай орны байгаль орчинтой холбоотой анхны нийтлэл юм. Тэрчлэн монгол сэхээтнүүд гаргаж байсан ууган тогтмол хэвлэлүүдийн нэг "Нийслэл хүрээний сонин бичиг"-т байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаар нийтлэл, материал гарч байжээ. Ийнхүү Монголд сэтгүүл зүй үүссэн цагаасаа эхлэн байгаль экологийн асуудлыг байнга тусгаж ирсэн агаад 1980-аад оны 2-р хагаст экологийн шилдэг нийтлэлийн жишиг болсон Ц.Балдоржийн "Далай ээж цаазын тавцанд", ("Үнэн", 1987, №233), Ш.Цэен-Ойдовын "Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ" ("Үнэн", 1987, №236) зэрэг нийтлэл бичигдэж олон нийтийн санаа бодлыг эзэмдэж, байгалийн баялаг утгаж үгүй болж байгааг харанга дэлдэн зарласан юм гэж эрдэмтэд онцолжээ¹.

Экологийн сэтгүүл зүйн оргил үе хэмээн онцолсон 1980-аад он, түүний дараах 1990-ээд оны тогтмол хэвлэл дэх экологийн нийтлэлийн сэдэв, төрөл зүйл, бичлэгийн онцлог хийгээд дээрх онуудын хоорондын ялгааг гаргахаар судаллаа.

Судалгааг хийхдээ 1980-аад оны сүүлийн гурван он тус бүрээс 4 сарыг сонгон авч, "Үнэн" сонинд нийт 12 сарын хугацаанд гарсан экологийн нийтлэл, 1990-ээд оноос мөн гурван он тус бүрээс дөрвөн сар нийт 12 сарыг сонгон авч, тухайн үеийн төвийн томоохон хэвлэл болох "Засгийн газрын мэдээ", "Ардын эрх" сонинуудын экологийн нийтлэлүүдэд судалгаа хийлээ. Нийт гурван сонины зургаан жилийн, 24 сарын, 770 дугаарт гарсан 250 орчим экологийн нийтлэлийг түүвэрлэн авч үзсэн болно.

1980-1990 оны тогтмол хэвлэл дэх экологийн сэдвийн тоо хэмжээ улирлын чанартайгаар өөрчлөгдөхгүй тогтмол байсан. Энэ нь экологийн сэдэв энэ үеийн тогтмол хэвлэлд өөрийн гэсэн байр суурьтай байсныг харуулж байгаа юм. Хэдий тийм боловч зай талбайнхаа маш бага хувийг (0,8-1,2%) экологийн сэдэвт зориулж байгаа нь учир дутагдалтай юм. Гэтэл гэмт хэргийн мэдээлэл нь экологийн сэдэвтэй харьцуулашгүй их байгаа нь сонин хэвлэл уншигчдын мэдэх хэрэгтэй мэдээлэлд ач холбогдол өгдөггүй нь харагдаж байна.

1980-1990-ээд оны тогтмол хэвлэлд экологийн дараах үндсэн сэдвүүдийг тусгаж байжээ:

- Мод, ойн нөөцийн хомсдол
- Голын ус, усны бохирдол
- Дархан цаазат газар
- Ан амьтан
- Цөлжилт, хөрсний элэгдэл
- Ашигт малтмал, алт
- Байгаль хамгаалал

- Байгалийн шинжлэл
- Бэлчээрийн даац, хөрсний бо-
хирдол
- Хог хаягдал
- Агаарын бохирдол
- Байгалийн гамшиг.

Тусгаж байсан сэдвийн хувьд 1980-аад он 1990-ээд оноосоо ялгаатай байна. Иргэдийн ахуй амьдрал, эрүүл мэнд, үр хүүхдэд ямар нөлөө, хор уршиг, эсвэл ач холбогдолтойг тайлбарлан таниулсан мэдээлэл сонирхол татахуйц, үр өгөөж өндөр байдаг. Энэ үүднээс авч үзвэл 1980-аад оны "Үнэн" сонин, тухайн үед бодитоор нүүр-лээд байсан эколо-гийн

тэнцвэрт байдлын алдагдал, бай-галь орчинтойгоо хайр гамгүй харьцаж байгаа иргэдийн үйл ажиллагаа, түүнийг хамгаалах гэсэн эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүд, иргэдийн санаачлага ажил үйлийг тусгаж олон нийтийн анхаарлыг энэ асуудал руу хандуулж чадаж байсан нь тусгаж байсан нийтлэл, сэдвүүдээс харагдаж байгаа юм. Хамгийн их тусгаж байсан сэдэв нь ойн нөөцийн хомсдол, ой модны хайр гамгүй огтлолт, хэрэглээ байсан. Энэ тухай "Эх орны ногоон хүрэм сэглэгдэж байна" нэртэй томоохон цуврал нийтлэлүүдээр бичиж, түүний мөрөөр "Сэглэгдэж байгаа

ногоон хүрмээ сэргээе", "Мөнгөлөг гацуур цомын төлөө" зэрэг ойг нөхөн сэргээх, ойн нөөцийг хамгаалах асуудлыг бүх нийтээрээ ярьж бичиж, тэмцэж эхэлсэн нь сонины экологийн сэдвийн дийлэнх хувийг эзлээд зогсохгүй, нийтлэл үр өгөөжөө үзүүлж иргэд, олон нийтийг энэ асуудал руу

татан оролцуулж чадсан нь харагдаж байгаа юм. Дараа нь голын усны бохирдол, томоохон нуур голуудын ширгэлт, дархан цаазат газрын хамгаалалт, ургамал, ан амьтны үр ашиг, үржил шимийн тухай сэдэв орж байсан ба уншигчдад эх дэлхий байгалийн оршин тогтох учир зүй, хайрлан

«

Экологийн сэтгүүл зүй нь иргэдийн байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах санаа сэдлийг төрүүлэх зорилготой олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжиж буй нийтлэл, нэвтрүүлгийн цогц юм. Байгаль орчны сэдэв глобаль шинжтэй, хүн бүрийн амьдрал ахуйд их ойрхон асуудал мөн.

»

хамгаалахын утга учир, байгалийн юмс үзэгдлийг хоорондын зохицолдолгоо зэргийг танин мэдүүлсэн, тайлбарлан таниулсан шинжтэй байгаль хамгаалал, байгалийн шинжлэлийн тухай сэдэв нэлээд их байсан нь сайшаалтай.

Харин 1990-ээд оны хувьд ан амьтны сэдэв хамгийн өндөр хувьтай гарсан. Энэ нь хулгайн ан, хууль бусаар ан амьтан агнаад хилээр гаргах гээд баригдсан тухай мэдээлэл байлаа. Тухайбал: "Хулгайгаар шонхор хил давуулахыг завдаж байна" ("Ардын эрх", 1998.09.25, №226), "Буга нэн ховор амьтны тоонд орлоо" ("Засгийн газрын

мэдээ", 1988.10.13, №205), "Чив, сүүл, эвэр хураалгажээ" ("Ардын эрх", 1998.12.01, №283), "Хасагт хайрханы хориод согоо агнажээ" ("Ардын эрх", 1998.12.09, №290) гэх мэт үйл явдлын шинжтэй мэдээлэл голложээ. Дараа нь алт, ашигт малтмалын олборлолтын сэдэв орсон нь мөн л "Монгол улс алтаа өөрөө цэвэршүүлнэ" ("Ардын эрх", 1998.09.05, №209), "Алтны орлогыг хувь хүмүүс завшжээ" ("Ардын эрх", 1992.01.10, №315), "Жуулчид хууль бусаар алт олборлож байжээ" ("Ардын эрх", 1998.09.02, №206), "Алтны зарим уурхайн ажлыг түр зогсооно" ("Ардын эрх", 1998.09.18, №221) зэрэг Монгол улсад алт олборлолт ихсэж байгаатай холбогдсон үйл явдлын мэдээлэлүүд байлаа.

Байгаль орчны ашиглалт хамгаалалт, сүйрлийн тухай нилээд ерөнхий, идэвхгүй шинжтэй мэдээлэл багагүй хувийг эзэлж байсан нь энэ үеийн сул тал юм. Энэ үед 1980-аад оны адил ой мод, модны нөөц, баялгийг хайр гамгүй ашиглаж сүйтгэж байгаа мэдээлэл бас чамлахааргүй хувийг эзэлж байлаа. Энэ сэдэв өдгөө ч экологийн нийтлэлийн үндсэн сэдэв байсаар л байгаа. 1980-аад онтой харьцуулахад тухайн сэдвээр цуврал нийтлэл бичих, нийтлэлийн мөрөөр арга хэмжээ авах, янз бүрийн арга хэмжээ зохиох ажил маш бага хийгдэж байсан. Нэг асуудлын тухай нэг л удаа мэдээлээд өнгөрөх төдий байсан нь үр нөлөө муутай юм.

1980-1990-ээд оны тогтмол хэвлэл дэх экологийн нийтлэлийн бичлэгийн төрөл зүйл.

Мэдээллийн төрөлд баримт давамгайлдаг бол экологийн нийтлэлд тайлбар зохилдог онцлогтой. Тиймээс экологийн нийтлэлийг мэдээллийн бичлэгийн төрөл зүйл биш, нийтлэл уран сайхны, задлан шинжилсэн төрөл зүйлээр бичвэл үр нөлөө өндөртэй. 1980-аад оны "Үнэн" сонины экологийн нийтлэлийн бичлэгийн төрөл зүйлийн хувьд асуудал дэвшүүлсэн нийтлэл өгүүлэл, сурвалжлага, танин мэдүүлэх нийтлэл өгүүлэл давамгайлж, мэдээ, ярилцлага зэрэг мэдээллийн төрөл зүйл маш бага байгаа нь экологийн сэтгүүл зүйн дээрх мөн чанартай нийцэж байгаа юм. Иргэд олон нийт байгаль орчны асуудалд их анхаардаг байсны нэг илрэл нь иргэдийн захидал, санал, зөвлөгөө, уриалга зэрэг багагүй нийтлэгдэж нийт нийтлэлийн 10-аад хувийг эзэлж байгаа явдал юм.

Иргэдийн захидал 1987 оноос хойш багассаар 1990-ээд онд бараг байхгүй болсон, өнөөгийн сонин хэвлэлд ч иргэдийн санал маш бага тусгагддаг нь өдгөө нийгмийн тулгамдсан асуудлуудыг зүй ёсоор тэргүүлж байгаа байгаль орчны элэгдэл эвдрэл, тэнцвэрт байдлын алдагдал зэрэг асуудлыг өнөөдрийн уншигч, олон нийт огт анхаардаггүй нь харагдаж байгаа юм. 1990-ээд оны экологийн нийтлэлийн ихэнх хувийг мэдээллийн бичлэгийн төрөл зүйл болох мэдээ, ярилцлага, сурвалжлагын хэлбэрээр

бичжээ. Асуудал дэвшүүлсэн нийтлэл 10-20 хувь, танин мэдүүлэх, шинжлэлт нийтлэл, иргэд олон нийтийн захидал зэрэг нь маш бага хувь (6 хувь) зарим нь бүр огт байхгүй байгаа нь 1990-ээд оны тогтмол хэвлэл дэх экологийн нийтлэл хуурай мэдээлэл төдий олон нийтэд тухайн асуудлыг хүргэх үр нөлөөний хувьд маш муу байсан гэж дүгнэж болохоор байгаа юм. Учир нь 1990 оны "Ардын эрх", "Зууны мэдээ" сонинуудын экологийн нийтлэлийн 30-60 гаруй хувийг гурав-дөрөвхөн өгүүлбэр бүхий мэдээ эзэлж байгаа юм.

Дараагаар нь байгаль орчин сүйтгэж, хууль бусаар ан агнаж, алт олборлож байгаа тухай сурвалжлага 25 орчим хувь эзэлж, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага 15 хувь, экологийн сэдвээр бичдэг цөөн сэтгүүлчийн асуудал дэвшүүлсэн өгүүлэл 10 орчим хувь эзэлжээ. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан байгаль орчны талаарх иргэдийн мэдлэгийг сайжруулах, байгаль орчноо хамгаалах, хайрлах ажил үйлст уриалах нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын нэн тэргүүний үүрэг болоод байгаа юм.

1980, 1990-ээд оны тогтмол хэвлэлд экологийн сэдвээр дагнан бичдэг сэтгүүлчид. Манай сэтгүүл зүйд байгаль орчны сэдвийг нэг талаас мэргэжлийн сэтгүүлчид, нөгөө талаас мэргэжлийн хүмүүс бичдэг. Эдгээрийн аль аль нь учир дутагдалтай. Сэтгүүл-

чийн бичсэн нийтлэл сонирхолтой атлаа баримт ашиглалт хангалтгүй, асуудлынхаа гүнд нэвтрэн орж чадаагүй, хувийн үзэл бодол хэт давамгайлсан сул талтай байдаг бол, мэргэжлийн хүний бичсэн нийтлэл ашигласан баримт, сонгосон сэдэв, асуудлын үр дагвар гарах арга замыг тусгасан зэргээрээ хувьгүй илүү ч хэл найруулга болхи, мэргэжлийн нэр томьёо их оруулсан, ойлгомжгүй, нуршуу, уйтгартай болдог. Экологийн сайн нийтлэл бичих нь нэг талаас сэтгүүлчийн ур чадвар, нөгөө талаас экологийн мэдлэг шаардсан нарийн төвөгтэй ажил юм. Иймээс экологийн мэдлэгтэй сэтгүүлч байх зайлшгүй шаардлага тавигдаж байгаа юм².

1980-аад оны "Үнэн" сонины экологийн нийтлэлийн зохиогчдын дийлэнх хувь нь эрдэмтэн, мэргэжилтнүүд, байгаль орчны яамны ажилтан эзэлж байв. Энэ нь тухайн үед сэдэв шинэ тутам энэ талаар мэдлэгтэй сэтгүүлч цөөхөн, тиймээс асуудлын учир зүйг сайн мэддэг, энэ талаар судалгаа шинжилгээ хийж буй эрдэмтэд, мэргэжилтнүүд их бичиж байсантай холбоотой болов уу. Харин экологийн асуудлаар дагнан бичдэг, байгаль орчны сэдвээр мэдлэг сайтай сэтгүүлчдийн ур чадварын маш өндөр төвшинд бичсэн цөөн хэдэн нийтлэл олон нийтийн анхаарлыг татаж, дэвшүүлж тавьсан асуудлын мөрөөр арга хэмжээ авахуулж, амжилтанд хүрсэн байдаг Жишээлбэл 1980-аад оны экологийн сэдвээр дагнан бичдэг байсан сэтгүүлчид Г.Жамц, Т.Дамдин, З.Пүрэв-

рагчаа нарын "Эх орны ногоон хүрэм сэлэгдэж байна" ("Үнэн", 1987, №47) цуврал нийтлэл, Ц.Балдоржийн "Далай ээж минь цаазын тавцанд" ("Үнэн", 1987, №233), "Далайн мандал дээр сурвалжилсан тэмдэглэл" ("Үнэн", 1989, №219), С.Ногоя "Хойч үеийнхэнд минь хожуул үлдэх вий" ("Үнэн", 1988, №182) зэрэг нийтлэлийг нэрлэж болно.

1990-ээд онд экологийн асуудлаар бичдэг сэтгүүлдээс нэрлэвэл "Засгийн газрын мэдээ" сонины хувьд Б.Батбилэг, "Ардын эрх" сонинд Ж.Мягмарсүрэн нар даацтай хэд хэдэн асуудал дэвшүүлсэн нийтлэл бичсэн байна. 1990-ээд оны хувьд сэтгүүлчид дийлэнхи хувийг, 1998

онд л гэхэд 97 хувийг сэтгүүлчид бичиж байсан үзүүлэлт бидний судалгаагаар гарсан. Өөрөөр хэлбэл байгаль орчны мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачдын санал дүгнэлт дэвшүүлсэн асуудал энэ үед маш бага туссан юм. Энэ нь өнгөн дээрээ экологийн асуудлыг сэтгүүлчид ихээр сонирхон бичиж байсан мэт харагдаж байгаа ч үнэн чанартаа экологийн сэдвээр дагнан бичдэг сэтгүүлчид маш цөөхөн байсны илрэл билээ. Энэ үзүүлэлт дийлэнх хувийг

мэдээ, ярилцлага, сурвалжлага эзэлж байгаатай шууд холбоотой.

1980-1990 оны тогтмол хэвлэл дэх экологийн булан нүүр. Экологийн сэдэвт нийтлэл нь тогтмол нүүр буланд, тогтсон хөмсөг гарчиг дор байршуулж байвал өөрийн гэсэн уншигчдын хүрээтэй болж, энэ сэдвийн хүртээмж илүү дээшлэх ач холбогдолтой.

«
*1980-аад оны 2-р хагасыг
Монголын экологийн сэтгүүл зүйн
хөгжлийн хамгийн дэвшилттэй
үе хэмээн тодорхойлсон
судлаачдын дүгнэлтийг бидний
судалгаа бүх талаараа баталж
байна. Харин 1990-ээд оны
экологийн нийтлэлд бүх талаараа
чанарын ухралт гарч, экологийн
нийтлэлийн уншигчидад хүрэх үр
нөлөө буурч, экологийн сэтгүүл
зүйн хөгжил зогсонги байдалд
орсон гээж үзэж байгаа юм.*

»

1980-аад оны "Үнэн" сонинд "Хүн, байгаль, хууль", "Дархан газар", "Бүх нийтийн чанарын үзлэг", "Байгаль хамгаалах сард", "Байгаль эхээ хайрлан хамгаалъя", "Мөнгөлөг гацуур цомын төлөө", "Эх орны ногоон хүрэм" зэрэг тогтсон нүүр, булангуудад экологийн

нийтлэл хэвлэгдэж байсан. "Үнэн" сонины экологийн нийтлэлийн дийлэнх хувь нь тогтсон буланд гарч байсан байна. Харин 1990-ээд онд байдал өөрчлөгдсөн юм. 1990-ээд оны эхэн үедээ тал орчим хувь нь тогтмол буланд гарч байсан бол сүүл рүүгээ 90-100 хувь нь тогтсон булан нүүрэнд гардаггүй байсан.

Дүгнэлт

1980-1990 оны тогтмол хэвлэл дэх экологийн сэдэвтэй нийтлэлүүдийг

судалснаар тухайн үеийн экологийн нийтлэлийн эзлэх хувь хэмжээ, үндсэн сэдэв, бичлэгийн төрөл зүйл, сэтгүүлчид, нүүр, булан зэргийн онцлогийг гаргалаа.

- 1980-1990-ээд оны тогтмол хэвлэлүүдэд экологийн нийтлэл дунджаар 0,8-1,2 орчим хувийг эзэлж байгаа нь маш чамлалттай үзүүлэлт юм.

- Сэдвийн хувьд тодорхой цөөхөн асуудлын хүрээнд бичиж байв. 1980-аад онд ой мод, ойн нөөцийн ашиглалт хамгаалалт, усны бохирдол, голын ширгэлтийн сэдэв давамгай өндөр хувьтай гарсан нь дээрх сэдвүүд хоорондоо холбоотойн дээр өнөөг хүртэл хамгийн их яригддаг экологийн үндсэн асуудлын нэг юм. 1990-ээд онд ан, амьтан, түүний ашиглалт хамгаалалт, алт, ашигт малтмалын сэдвийг түлхүү тусгаж байжээ.

- 1980-аад оны бичлэгийн төрөл, зүйл нь танин мэдүүлсэн, асуудал дэвшүүлсэн нийтлэл, өгүүлэл давамгайлж, мэдээ, ярилцлага маш цөөн тохиолдож байв. Өөрөөр хэлбэл экологийн асуудлыг тусгахад хамгийн их тохирсон төрөл зүйлээр бичиж, энэ утгаараа ч нийтлэлийн үр нөлөө нь өндөр байжээ гэж дүгнэж болно. Харин 1990-ээд онд мэдээллийн бичлэгийн төрөл зүйл дийлэнх хувийг эзэлж байлаа.

- 1980-аад онд мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачид, 1990-ээд онд сэтгүүлчид голдуу экологийн сэдвийг тусгаж байв. Аль ч үед экологийн сэдвээр дагнан бичдэг цөөн хэдий ч сэтгүүлчид байсан. Гэхдээ байгаль

орчны мэдлэггүй сэтгүүлчийн бичсэн хуурай мэдээнээс асуудлынхаа мөн чанарыг мэддэг мэргэжилтний бичсэн нийтлэлийн үр нөлөө өндөр юм.

- 1980-аад онд экологийн тогтмол булан, нүүрт нийтлэлээ гаргаж байв. Энэ нь сонин хэвлэл экологийн асуудалд ач холбогдол өгч байсны нэг илрэл юм. Харин 1990-ээд онд экологийн дагнасан тогтмол булан, нүүр байсангүй. Энд тэнд хэсэг бусаг замбараагүй байдлаар байрласан мэдээллийн уншигчид хүрэх нөлөө нь муу, өөрийн гэсэн уншигчидтай болох боломж тааруу, сонин энэ асуудалд анхаарлаа төдий л хандуулахгүй байгаа гэсэн үг юм.

- 1980-аад оны хоёрдугаар хагасыг Монголын экологийн сэтгүүл зүйн хөгжлийн хамгийн дэвшилттэй үе хэмээн тодорхойлсон судлаачдын дүгнэлтийг бидний судалгаа бүх талаараа баталж байна гэж үзэж байна. Харин 1990-ээд оны экологийн нийтлэлд бүх талаараа чанарын ухралт гарч, экологийн нийтлэлийн уншигчидад хүрэх үр нөлөө буурч, экологийн сэтгүүл зүйн хөгжил зогсонги байдалд орсон гэж үзэж байгаа юм.

Ишлэл

¹ Ч о й с а м б а Ч. 2002. Экологийн сэтгүүл зүй. УБ., 12 дахь тал.

² Ч о й с а м б а Ч. 2002. Экологийн сэтгүүл зүй. УБ., 17 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ч о й с а м б а Ч. 2002. Экологийн сэтгүүл зүй. УБ.
2. Н о р о в с ү р э н Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. Тэргүүн боть.
3. "Үнэн" сонины 1987 оны 1-4-р сар, 9-12-р сар, 1988 оны 5-8-р сарын дугаарууд
4. "Ардын эрх" сонины 1992 оны 1-4-р сар, 1995 оны 5-8-р сар, 1998 оны 9-12-р сарын дугаарууд
5. "Засгийн газрын мэдээ" сонины 1992 оны дугаарууд.

Abstract

By research ecological article on 1980-1990s papers, their percentage of publication, main subject, type of the writing, journalists, and their fixed location in the publication was studied. In 1980-1990s paper, ecological article only took 0.8-

1.2 percentage of the publication, this is very small percentage. Their subject were very limited in coverage, in 1980s forestry, forestry reserve protection, water pollution, river waterway reduction were main subject. However in 1990s game, game management, gold, and other mining related subjects were the main subjects.

In 1980s writing types were trying to shed light on the problem on the issue, interview was very limited. In 1990s informative type writing makes up the major percentage. In 1980s scientist and researchers were the main contributors, in 1990 journalists were main contributors, but their numbers were limited. In 1980s publications had fixed location for ecological related article, however in 1990s there wasn't any fixed location for the matter. Finally, researchers agree that 1980 was the golden period of ecological journalism. However, in 1990 ecological articles were worse in quality, their coverage was limited and it almost came to halt.